



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 745

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа Дорнод аймаг дахь Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 2 нэрийн, нийт 62,421,181.73 (жаран хоёр сая дөрвөн зуун хорин нэгэн мянга нэг зуун наян нэгэн төгрөг далан гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Дорнод аймаг дахь Гаалийн газрын дарга Б.Гэрэлт-Од, Дорнод аймаг дахь Политехник коллежийн захирал Л.Хишигтогтох нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Акталсан хөрөнгийг Дорнод аймаг дахь Политехник коллежийн сургалтын материалаг баазыг бэхжүүлэх зорилгоор, сургалт, дадлагын хичээлд ашиглуулахаар хүлээлгэн өгөх.

2.4. Акталж, данснаас хассан автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123007211
35-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн
...~~7.7~~ дүгээр тогтоолын хавсралт



Дорнод аймаг дахь Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
Дорнод аймгийн Политехник коллежийн сургалт, дадлагын
хичээлд ашиглахаар акталж, данснаас хасах автомашин

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн , ашиглалтад орсон он	Гүйлт, км (мянга)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Киа бонго, 21-46 ДОР, арал№KNCSHY74CBK516043	2010/ 2010	615,5	33,921,181.73
2	Фургон, 14-13 ДОР, арал№374100E0437107	2014/ 2014	653,9	28,500,000.00
	Нийт дүн			62,421,181.73 (жаран хоёр сая дөрвөн зуун хорин нэгэн мянга нэг зуун наян нэгэн төгрөг далан гурван мөнгө)